


МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2021 оны III улирлын тойм мэдээ

OTMongolia OTMongolia Oyu Tolgoi OTMongolia OTMongolia

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Аюулгүй ажиллагаа нь бидний нэн тэргүүний зорилт. Аюултай гэж үзсэн ямар ч ажлыг ажилтан бүр шууд **зогсоох** эрхтэй.



2021 оны гуравдугаар улирлын байдлаар

17,925,439
Хүн/цаг

2021 оны гуравдугаар улирлын байдлаар гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.13 ногдож байгаа нь Рио Тинто группийн хэмжээнд аюулгүй ажиллагааг сайн хангадаг уурхайн нэг болж байна.



Гүйцэтгэл
0.13



Ноцтой эрсдэлийн удирдлага

87,936
Магадлагаа

Амь нас хамгаалах зорилготой "Ноцтой эрсдэлийн удирдлага" хөтөлбөрийн хүрээнд 87,936 магадлагаа хийлээ.

МОНГОЛ АЖИЛТНУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Үүрэг 90%

96%

Нийт ажиллах хүчний 96 хувийг монгол иргэд бүрдүүлж байна. Үүнээс 25.8 хувь нь гүний уурхайн төслийн ажилтнууд юм.



БОЛОВСРОЛ СУРГАЛТ

(Нийт хүн/цаг)



Нийт 198,818 хүн/цагийн сургалтад ажилтнуудаа хамруулан ур чадварыг нь өсгөсөөр байна.

БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР
(Тэтгэлэг, бусад хөтөлбөрүүд)
2011 оноос хойш
3,532 оюутан,

ЗАЛУУСЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР
2013 оноос хойш ахлах ангийн 1,180 сурагч,

"ГОВИЙН ОЮУ" САН, МАЛЧИН ӨРХИЙН ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ
2010 оноос хойш Өмнөговийн 432 оюутан тус тус хамрагджээ.

ҮНДЭСНИЙ ХУДАЛДАН АВАЛТ


(2010 - 2021/III улирал, сая ам.доллар)



2021 оны гуравдугаар улирлын байдлаар үйл ажиллагааны худалдан авалтын баг 739 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 469 нь үндэсний компаниуд байв. Эдгээр үндэсний компаниуд худалдан авалтынхаа 75 хувийг зарцуулав. 2010 оноос хойш үндэсний худалдан авалтад 3.8 тэрбум ам.доллар зарцуулсан.


УСНЫ ХЭРЭГЛЭЭ

(Нэг тонн хүдэр боловсруулахад зарцуулсан усны хэмжээ, шоо метр, сараар)




УС ДАХИН АШИГЛАЛТ

(хувь, сараар)



УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2013 - 2021/III улирал)



123.4
тэрбум төгрөг

Нэг тонн хүдэр боловсруулахдаа 0.4м³ буюу дэлхийн ижил төрлийн уурхайнуудын ашиглалтын дунджаас даруй гурав дахин бага ус ашиглаж байна.

87.15%

2021 оны гуравдугаар улиралд зорилтоо давуулан биелүүлж ус дахин ашиглалтын түвшинг дунджаар 87.15 хувьд хүргэв.


МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2021 оны III улирлын тойм мэдээ

OTMongolia OTMongolia Oyu Tolgoi OTMongolia OTMongolia

ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР

(2010 - 2021/III улирал, сая ам.доллар)



2010 оноос хойш өсөн нэмэгдсэн дүнгээр

3.5

ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫГ татвар хураамж, бусад төлбөрт төлжээ.

2010 - 2021 оны гуравдугаар улиралд татвар, хураамж, үндэсний компаниудад төлсөн НӨАТ зэрэг бусад төлбөрт 3.5 тэрбум ам.долларыг төлсөн. 2021 оны эхний гурван улиралд татвар, хураамж бусад төлбөрт 590 сая ам.доллар төлжээ.


* "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.

** Энэ дүнд олон улсын арбитра хэлэлцэж буй 356 сая ам.долларын төлбөр багтсан болно.

ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ


(2010 - 2021/III улирал, тэрбум ам.доллар)

2010 оноос хойш үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалинд 13 тэрбум ам.доллар зарцууллаа.



ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД


(сая ам.доллар)



2021 оны гуравдугаар улирлын байдлаар тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд 5.2 сая ам.долларын санхүүжилт олгожээ.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ


(2010 - 2021/III улирал, сая ам.доллар)



2021 оны гуравдугаар улирлын байдлаар Өмнөговь аймагт бүртгэлтэй 89 ханган нийлүүлэгч манайд бараа, үйлчилгээ нийлүүлэв. 2010 оноос хойш Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалтад нийт 777 сая ам.доллар зарцуулжээ.

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ


(мян.тонн)



2021 оны гуравдугаар улиралд 41,935 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэв. 2021 онд 150,000 - 180,000 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэх төлөвлөгөөний биелэлт хангалттай байна.

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ


(мян.унц)



2021 оны гуравдугаар улиралд 130,799 унц баяжмал дахь алт үйлдвэрлэв. 2021 онд 400,000 - 480,000 унц баяжмал дахь алт үйлдвэрлэх төлөвлөгөөний биелэлт хангалттай байна.

ГҮНИЙ УУРХАЙН ХӨНДЛӨН НЭВТРЭЛТ

(метр, сараар)



2021 оны гуравдугаар улиралд гүний уурхайн хөндлөн малталтын гүйцэтгэл 2,229.3 метр, харин налуу амны малталтын ажил 642.8 метрийн ахицтай байлаа.